



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/250

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Худалдан  
авах ажиллагааны албаны эргэлтийн  
бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,243,000.0 /Нэг сая хоёр зуун дөчин гурван мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Сонгинохайрхан дүүргийн худалдан авах ажиллагааны алба /Х.Батхүү/-нд зөвшөөрсүгэй.


2. Татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 2 нэр төрлийн 1,243,000.0 /Нэг сая хоёр зуун дөчин гурван мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сонгинохайрхан дүүргийн худалдан авах ажиллагааны алба /Х.Батхүү/-нд үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус даалгасугай

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
газрын даргын 2019 оны 17...сарын  
10. өдрийн 0150 дугаар тушаалын хавсралт



Актлах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны газар

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Проектор Aser	2013.04.29	ш	1	935,000	935,000	935,000	-	Эвдэрсэн	татах
2	Тог баригч	2013.04.29	ш	1	308,000	308,000	308,000	-	Эвдэрсэн	татах
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>				<b>2</b>		<b>1,243,000</b>	<b>1,243,000</b>	-		
<b>Нийт данснаас хасах хөрөнгийн дүн</b>				<b>2</b>		<b>1,243,000.00</b>	<b>1,243,000</b>	-		
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Актлах хөрөнгө										
Татан төвлөрүүлэх хөрөнгө						1,243,000.00	1,243,000.00	-		
Худалдсанаас олох орлого										
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/										